



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/136

Чойр

### Мөнгөн төлбөрийн орлогыг зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэлийг хөтлөн, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах тухай 215 дугаар журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасан мөнгөн төлбөрийн 50 хувийг улсын төсөвт, үлдэх 50 хувийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хагас, бүтэн жилээр тооцоо хийж шилжүүлэхийг аймгийн төсвийн ерөнхий санхүүч (Б.Соёлмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасан мөнгөн төлбөрийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ